

БАТЛАВ
НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН БИЕИЙН
ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ ДАРГА

Ж. ГАНБОЛД

20/8 оны 07 сар 31 өдөр

БАТЛАВ
“НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ГАЗАР”-ЫН ДАРГА

Д. БАТСУХ

5284236 СБТ 48076 27200000
2018 оны 07 сар 31 өдөр

ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ

2018 оны 07 дугаар сарын 23

Улаанбаатар хот

№ 105

Нэг талаас “Захиалагч” гэх)-ыг “Нийслэлийн аялал жуулчлалын газар”-ын Бодлого төлөвлөлтийн хэлсийн дарга төлөөлж В.Батчимэг нөгөө талаас Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хороо (цаашид (“Гүйцэтгэгч” гэх)-ийг төлөөлж Нийтийн биеийн тамирын хөгжлийн хэлсийн дарга А.Болдмаа нар энэхүү гэрээг байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ЗААЛТ

1.1. Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/665 дугаар захирамжийн хүрээнд зохион байгуулагдах Даншиг наадам-Хүрээ цам-2018” наадмын Үндэсний бөхийн барилдаан, Үндэсний сурын үзүүлэх харвааг зохион байгуулахтай холбоотой харилцан зохицуулахад энэхүү гэрээний зорилго оршино.

ХОЁР. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

2.1. Даншиг наадам-Хүрээ цам-2018” наадмын Үндэсний бөхийн барилдаан, Үндэсний сурын үзүүлэх харвааг 2018 оны 08 дугаар сарын 04, 05-ны өдөр “Хүй долоон худаг”-т зохион байгуулана.

ГУРАВ. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛБӨР

3.1. Даншиг наадам-Хүрээ цам-2018” наадмын Үндэсний бөхийн барилдаан, Үндэсний сурын үзүүлэх харвааг зохион байгуулахад шаардагдах зардал 39.746.000 (зучин есөн сая долоон зуун дөчин зургаан мянган) төгрөгийг Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хорооны дансанд шилжүүлэх.

3.2. Төлбөрийг 2018 оны 07 дугаар сарын 31-ны өдрөөс өмнө “Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хороо”-ны Төрийн сан банк 100200035401 дансанд шилжүүлнэ.

ДӨРӨВ. ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

4.1. Даншиг наадам-Хүрээ цам-2018” наадмын Үндэсний бөхийн барилдаан, Үндэсний сурын үзүүлэх харвааг өндөр хэмжээнд зохион байгуулахад бэлтгэл ажлыг урьдчилан сайтар ханган хамтран ажиллах.

4.2. Даншиг наадам-Хүрээ цам-2018” наадмын Үндэсний бөхийн барилдаан, Үндэсний сурын үзүүлэх харвааг зохион байгуулахад зориулсан Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/665 дугаар захирамжаар батлагдсан зардлаас гэрээ байгуулсан өдрөөс хойш ажлын нэг өдөрт багтаан гүйцэтгэгч талд шилжүүлэх.

ТАВ. АЖИЛ ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

5.1. Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/665 дугаар захирамжийн хүрээнд зохион байгуулах Даншиг наадам-Хүрээ цам-2018" наадмын Үндэсний бөхийн барилдаан, Үндэсний сурын үзүүлэх харвааг зохион байгуулахад зориулан баталсан төсөв зардлыг захиран зарцуулах.

5.2. Даншиг наадам-Хүрээ цам-2018" наадмын Үндэсний бөхийн барилдаан, Үндэсний сурын үзүүлэх харвааг зохион байгуулахтай холбоотой төсвийн зардлын үйл ажиллагаатай холбогдох тайлан мэдээ, холбогдох баримтыг арга хэмжээ дууснаас хойш ажлын 3 хоногт багтаан захиалагч талд тайлагнах.

ЗУРГАА. ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

6.1. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүйгээс учруулсан хохирлыг гэм буруутай тал нь хохирогч талдаа нөхөн төлөх үүрэгтэй.

6.2. Торгууль, алданги төлсөн нь материалыг устгасан, гэмтээснийг нөхөн төлөх үүрэг гүйцэтгэхээс чөлөөлөгдөхгүй.

ДОЛОО. БУСАД ЗААЛТ

7.1. Гэрээ байгуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно. (Эсвэл хүчин төгөлдөр болох өдрийг тохиролцож болно)

7.2. Гэрээний хугацаа, нөхцөл байдлын талаар өөрчлөлт оруулахаар бол хоёр тал харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

7.3. Хэрэв талуудын хооронд маргаан гарвал талууд үл маргах журмаар шийдвэрлэх ба маргаанаа шийдвэрлэж чадахгүйд хүрвэл (шүүх, арбитр)-аар шийдвэрлүүлнэ (доогуур нь зур).

НАЙМ. ГЭРЭЭНД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ЖУРАМ

8.1. Ажил гүйцэтгэх явцад гэрээнд оруулсан аливаа нэмэлт, өөрчлөлт нь зөвхөн бичгээр хийгдэж талуудын гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

8.2. Учруулсан хохирлыг арилгахтай холбогдсон хууль тогтоомжид заасан үндэслэлээр 2 тал харилцан тохиролцож гэрээг хугацаанаас нь өмнө цуцалж болно.

ТАЛУУДЫН ХУУЛЬ ЁСНЫ ХАЯГ

Захиалагчийн хаяг:

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Засаг захиргааны 4 дүгээр байр 7-н давхарт, Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын газар Утас:+976-11-312785, +976-11-328977, 9911-6171

Гүйцэтгэгч хаяг:

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Засаг захиргааны 4 дүгээр байр 5-н давхарт, Нийслэлийн Аялал жуулчлалын газар Утас:+976-7011-8687, 70138687

ГЭРЭЭНИЙ БАТАЛГААЖУУЛАЛТ:

ЗАХИАЛАГЧ:

НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ НБТХХ-ЫН ДАРГА

А.БОЛДМАА

ГҮЙЦЭТГЭГЧ:

"НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЧЛАЛЫН ГАЗАР"-ЫН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН ДАРГА
В.БАТЧИМЭГ